

**Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
2024 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАГНАЛ**

2025.03.23

Борхойн тал

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
Тайлагнах хугацаа	2024 оны 01 дүгээр сарын 01-нээс 2024 оны 12 дугаар сарын 31
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Э-Транс ложистикс ХК, ETR, 99117631
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Ачаа тээвэр, гаалийн нэг цэгийн үйлчилгээ
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК, 2014 оны 09 дүгээр сарын 17
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	46,200,000 ширхэг
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Тайлан бэлтгэсэн: Дотоод ажил хариуцсан ажилтан С.Ганбат Хянасан: Гүйцэтгэх захирал Ч.Энхболд
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/

	Санхүүгийн байдлын үзүүлэлт	<p>Эргэлтийн хөрөнгийн дүн – 4,297,803,527.83 Эргэлтийн бус хөрөнгийн дүн – 4,928,545,476.42 Нийт хөрөнгийн дүн – 9,226,349,004.25 Богино хугацаат өр төлбөрийн дүн – 148,470,444.01 Урт хугацаат өр төлбөрийн дүн – 3,139,341,571.66 Өр төлбөрийн нийт дүн – 3,287,812,015.67 Эзэмшигчдийн өмчийн дүн - 5,938,536,988.58 Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн – 9,226,349,004.25</p>
	Орлогын тайлан	<p>Борлуулалтын орлого (цэвэр) – 3,684,637,955.11 Нийт ашиг (алдагдал) – 3,684,637,995.11 Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) – 767,970,339.47 Татварын дараах ашиг (алдагдал) – 680,386,843.18 Нийт орлогын дүн - 680,386,843.18</p>
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	<p>Өмч - 4,620,000,000.13 Нэмж төлөгдсөн капитал - 154,000,000.00 Эздийн өмчийн бусад хэсэг - 774,858,080.00 Хуримтлагдсан ашиг – 389,678,908.45 Нийт дүн - 5,938,536,988.58</p>
	Мөнгөн гүйлгээний тайлан	<p style="text-align: center;">Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</p> <p>Мөнгөн орлогын дүн (+) – 4,102,675,297.84 Мөнгөн зарлага (-) – 3,287,703,345.60 Цэвэр мөнгөн гүйлгээ – 819,971,952.24</p> <p style="text-align: center;">Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</p> <p>Мөнгөн орлогын дүн (+) – 34,752,092.82 Мөнгөн зардагын дүн (-) – 1,071,882,301.26 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн - (1,037,130,208.44)</p> <p style="text-align: center;">Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</p>

	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлогийн дүн - 3,143,000,000.00 Мөнгөн зарлагийн дүн - 1,808,847,478.52 Бүх цэвэр мөнгөн гүйлгээ - 1,116,994,265.28 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл - 1,688,511,269.25
1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

1 Компанийн талаарх мэдээлэл

Э-Транс ложистикс ХХК нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу 2007 онд байгуулагдсан, 2010 онд Э-Транс ложистикс ХХК-д ачаа шилжүүлэн ачуулах терминалаа шилжүүлсэн Э-Транс ложистикс ХХК нь 2011 оны 12 дугаар сарын 06-ны өдөр нээлттэй хувьцаа гаргах хувьцаат компани болсон.

Компанийн хаяг: Дорноговь аймаг, Замын Үүд сум, 1 дүгээр баг, Төмөр замчдын өргөн чөлөө гудамж, 04-411 тоот Э-Транс ложистикс ХК-ийн байр. Утас: 02524543813

Компанийн улсын бүртгэлийн дугаар: 0610001001, Регистр: 3309665.

Э-Транс ложистикс ХК нь Зам, тээврийн хөгжлийн яамны 2019 оны 09 дүгээр сарын 04-ны өдрийн, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” болон Төмөр замын тээврийн тухай хууль, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, үндэсний холбогдох стандартын дагуу 3 жилийн хугацаатайгаар “Төмөр замын тээврийн аюулгүй байдлаар холбоотой объектын гэрчилгээ” КОД:0-2 Дагнасан хэрэглээний зам талбайн тусгай зөвшөөрлийг авсан.

Э-Транс ложистикс ХК нь Улсын бүртгэлийн гэрчилгээнд “Ачаа шилжүүлэн ачих” болон “Гадаад худалдаа” эрхлэхээр бүртгүүлсэн бөгөөд 2016 онд компанийн шинэчлэгдсэн дүрэмд дараах үйл ажиллагааг эрхлэхээр заасан байна. Үүнд:

- Ачаа шилжүүлэн ачих
- Гадаад, дотоод худалдаа
- Компанийн тухай хууль, эрх зүйн зохицуулалтуудын хүрээнд бусад үйл ажиллагааг гүйцэтгэх бөгөөд Монгол Улсын хуулийн дагуу эрх үүргээ хэрэгжүүлэн ажиллана гэж заасан байна.

Компанийн дүрмийн сан нь нэг бүр нь 100 төгрөгийн үнэтэй 46,200,000 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байна. Хувьцааны тоо ширхэг болон хувьцаа эзэмшигчдийн бүтэц дараах байдалтай байна.

Хувьцаа эзэмшигчийн нэр:	2023 он		2024 он	
	Эзэмшигч буй хувьцааны дүн/төг/	Хувь эзэмшил	Эзэмшигч буй хувьцааны дүн/төг/	Хувь эзэмшил
Э-Транс ложистикс ХК	2,310,000,000	50%	4,524,445,400	97.9%
Би Ди Сек ХК	1,373,977,000	29.74%	-	0.0%
Тасган инвест ХХК	510,229,800	11.04%	-	0.0%
ZNAHR ALENANDER	169,856,700	3.68%	-	0.0%
Би Ди Пи Эй Эф ХХК	128,445,700	2.78%	-	0.0%
Бусад ААН	6,925,400	0.15%	5,670,500	0.1%
Монгол улсын иргэд	86,618,300	1.87%	58,229,200	1.3%
Гадаад улсын иргэд	33,947,100	0.73%	31,530,600	0.7%
НИЙТ ДҮН	4,620,000,000	100%	4,619,875,700	100.0%
Үүнээс тусгаарлагдсан:				
Монгол улсын иргэд/З/			124,300	0.003%

Тайлант онд хувьцаа эзэмшигчдийн тоонд материаллаг дүнтэй өөрчлөлт орж, компанийн нийт хувьцааны 97.9 хувийг Э Транс ХХК эзэмших болсон. Нийт 3 иргэний 1243 ш тусгаарлагдсан хувьцаа байна.

2 Компанийн үйл ажиллагааны орчин

Компанийн хууль эрх зүй орчинд үйл ажиллагаанд нөлөөлөхүйц өөрчлөлт ороогүй. Компани нь гаалийн хяналтын талбайг өргөтгөх зориулалтаар шинээр 1 иргэнээс 460,000,000.00 төгрөгийн 3440 м2 газрыг худалдан авч бэлтгэл ажлыг хангаж байна.

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

хувьсах шинжтэй төлбөр, үлдэгдэл үнийн баталгааны дагуу төлөхөөр хүлээгдэж буй төлбөрүүдийг хамруулан авч үзнэ. Хувьсах шинжтэй гүрээсийн төлбөр нь ямар нэг индекс, хувь хэмжээнээс хамааралгүй (барра материал үйлдвэрлэлд зориулж гаргаагүй бол) бол түүнийг тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрнө.

6.10.10 Өөрийн хөрөнгө

Энгийн хувьцааг өөрийн хөрөнгөнд ангилна. Энгийн хувьцааны ногдол ашгийг зарласан үедээ өөрийн хөрөнгөнд хүлээн зөвшөөрдөг. Өөрийн хөрөнгийн гүйлгээний өртөгт зөвхөн өөрийн хөрөнгийн гүйлгээнд шууд холбоотой гаднын нэмэгдүүлсэн өртгөөс бусад өртгийг оруулахгүй.

6.10.11 Болзошгүй өр төлбөр ба хөрөнгө

Болзошгүй өр төлбөрүүд нь санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрөгдөөгүй бөгөөд санхүүгийн тайлангийн тодруулгад толилуулаа. Харин ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг компани хүртэх магадлалтай болсон үед санхүүгийн тайлангийн тодруулгад толилуулана.

6.10.12 Холбоотой талууд

Холбоотой талууд гэдэгт Компанитай дараах байдлаар холбогдсон аж ахуй нэгж болон хувь хүн орно. Үүнд:

- Компанитай дараах байдлаар холбогдсон хувь хүн эсвэл тухайн хувь хүний ойрын төрөл садан:
 - Компанид дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон;
 - Компанид томоохон нөлөөлөлтэй эсвэл
 - Компанийн эсвэл Компанийн толгой компанийн гол удирдах албан тушаалтнуудын нэг.
- Дараах нөхцөлүүдийн аль нэг нь биелсэн тохиолдолд аж ахуй нэгж нь Компанид хамааралтай болно. Үүнд:
 - Аж ахуй нэгж болон Компани нь нэг ижил Группийн гишүүд байх (толгой компани, охин компани болон нөгөө охин компани тус бүр нь бусадтайгаа холбоотой).
 - Нэг аж ахуй нэгж нь нөгөө аж ахуй нэгжийн хараат компани эсвэл хамтын хэлэлцээрт компани (эсвэл нөгөө аж ахуй нэгж нь гишүүн болох Компанийн хараат компани эсвэл хамтарсан хэлэлцээрт компани).
 - Аль аль аж ахуй нэгж нь нэг ижил гуравдагч этгээдийн хамтарсан хэлэлцээрт компаниуд.
 - Нэг аж ахуй нэгж нь гуравдагч аж ахуй нэгжийн хамтарсан хэлэлцээрт компани бөгөөд нөгөө этгээд нь гуравдагч аж ахуй нэгжийн хараат компани.
 - Аж ахуй нэгж нь Компанийн эсвэл Компанитай холбоотой аж ахуй нэгжийн ажиллагсдыг урамшуулах зорилгоор ажил эрхлэлтийн дараах тэтгэмж олгодог. Хэрвээ Компани нь уг хотөлбөрийг хэрэгжүүлдэг бол дэмжлэг хүртэж буй ажиллагсад нь мөн Компанитай холбоотой тал болно.
 - Аж ахуй нэгжийг (а)-д тодорхойлсон хувь хүн дангаараа эсвэл хамтран хяналт тогтоодог.
 - (а) (i)-д тодорхойлсон хувь хүн нь аж ахуй нэгжид томоохон нөлөөлөлтэй эсвэл уг аж ахуй нэгжийн (эсвэл аж ахуй нэгжийн толгой компанийн) гол удирдах албан тушаалтнуудын нэг.
 - Аж ахуй нэгж нь эсвэл Компанийн аль нэг гишүүн нь Компани эсвэл Компанийн толгой компанид гол удирдах албан тушаалтай.

7 Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө данс нь дараах үлдэгдэлтэй байна.

(Төгрөгөөр)	2023.12.31	2024.12.31
Касс дахь бэлэн мөнгө	550,803,542.02	1,528,883,978.52
Харилцах дахь мөнгө	20,713,461.95	159,627,290.73
Дүн	571,517,003.97	1,688,511,269.25
1.1 Касс дахь бэлэн мөнгө (Мянган төгрөгөөр)	2023.12.31	2024.12.31
Төгрөг	550,803,542.02	1,528,883,978.52
Дүн	550,803,542.02	1,528,883,978.52

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

1.2 Банкин дах харилцах данс

(валютаар)	2023.12.31	2024.12.31
Төгрөг MNT	20,713,461.95	159,627,290.73
Ам доллар USD	-	-
Дүн	20,713,461.95	159,627,290.73

8 Дансны авлага болон бусад авлага

Дансны авлагын хураангуй дараах байдалтай байна.

(төгрөгөөр)	2023.12.31	2024.12.31
Дансны авлага	17,495,784.15	1,734,727,718.13
Найдваргүй авлагын эрсдлийн сан	-	-
Дүн	17,495,784.15	1,734,727,718.13
(Мянган төгрөгөөр)	2023.12.31	2024.12.31
Бусад авлага	4,000,000.00	5,811,291.00
Найдваргүй авлагын эрсдлийн сан	-	-
Дүн	4,000,000.00	5,811,291.00

Компани нь 2022 онд СТОУС 9 буюу санхүүгийн хөрөнгийн бүртгэх тайлагнах стандартыг хэрэгжүүлсэн. Найдваргүй авлагын эрсдэлийн сан байгуулаагүй.

Борлуулалтын авлагын насжилтыг хоногоор дараах байдлаар харуулав.

(Төгрөгөөр)	0-90 хоног	90-180 хоног	180-270 хоног	270-360 хоног	360 дээш хоног	Нийт
Дансны авлага	66,000.00	3,250,000.00	-	-	1,731,411,718.13	1,734,727,718.13
Эрсдлийн сан	-	-	-	-	-	-
Дүн	66,000.00	3,250,000.00	-	-	1,731,411,718.13	1,734,727,718.13

9 Бараа материал

Бараа материал дансны хураангуй дараах байдалтай байна. Компани нь тайлант үеийн эцэст бараа материалын тооллогыг хийж өртөг, цэвэр боломжит үнэ цэнийг авч үзэн өртгөөр нь илэрхийлсэн.

(Төгрөгөөр)	2023.12.31	2024.12.31
Бэлэн бүтээгдэхүүн	4,275,910.55	1,452,370.91
Бараа	6,127,468.64	2,197,630.00
Хангамжийн материал	34,163,617.48	21,928,918.82
Бусад хангамжийн материал	12,223,948.72	5,352,375.45
Дүн	56,790,945.39	30,931,295.18

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

10 Урьчилж төлсөн зардал тооцоо

(Төгрөгөөр)	2023.12.31	2024.12.31
Худалдан авалтын урьчилгаа	246,947,443.64	837,821,954.27
Дүн	246,947,443.64	837,821,954.27

11 Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгийн өөрчлөлт, хөдөлгөөн дараах байдалтай байна. Компани биет бус хөрөнгийн хорогдлыг өмнөх жилийн үлдэх өртгөөс шууд хасаж тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрдөг.

(Төгрөгөөр)	Програм хангамж	Газар эзэмших эрх	Бусад биет бус хөрөнгө	Нийт дүн
2023.12.31-ний үлдэгдэл	2,849,544.84	271,274,744.12	6,575,000.00	280,699,288.96
Нэмэгдсэн				
Хорогдуулсан	891,597.12	-	900,000.00	1,791,597.12
2024.12.31-ний үлдэгдэл	1,957,947.72	271,274,744.12	5,675,000.00	278,907,691.84

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн

Санхүүгийн Тайлангийн Тодруулга

12 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн өөрчлөлт, хөдөлгөөн дараах байдалтай байна. Компани нь үндсэн хөрөнгөө дахин үнэлгээний загвар ашиглан бүртгэсэн, хөрөнгийн дүн, элэгдүүлэх хугацаа, арга нь өмнө хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөнд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн өгөөжийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах зорилгоор хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жилийн эцэс бүрд хянаж үздэг.

(төгрөг)	Барилга байгууламж	Машин, тоног төхөөрөмж	Тээврийн хэрэгсэл	Тавилга, эд хогшил	Компьютер дагалдах хэрэгсэл	Нийт дүн
ӨРТӨГ						
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,742,474,424.88	533,159,931.18	405,190,115.62	101,518,539.91	109,351,647.86	6,891,694,659.45
Өөрөө үйлдвэрлэсэн	-	-	-	-	-	-
Худалдаж авсан	194,196,335.00	71,726,290.40	144,545,454.55	53,559,350.00	20,137,711.82	484,165,141.77
Акталсан	-	172,282,099.10	7,217,706.10	30,331,537.77	71,256,160.00	281,087,502.97
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,936,670,759.88	432,604,122.48	542,517,864.07	124,746,352.14	58,233,199.68	7,094,772,298.25
ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ						
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,626,016,087.55	385,508,371.35	316,246,122.33	66,172,716.08	88,520,679.62	2,482,463,976.93
Байгуулсан элэгдэл	171,563,118.31	23,964,090.54	25,121,045.88	8,961,346.30	16,536,723.39	246,146,324.42
Данснаас хассан хөрөнгийн элэгдэл	-	173,451,323.46	7,217,706.10	31,550,598.13	71,256,160.00	283,475,787.69
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,797,579,205.86	236,021,138.43	334,149,462.11	43,583,464.25	33,801,243.01	2,445,134,513.66
ДАНСНЫ ЦЭВЭР ДҮН						
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	4,116,458,337.33	147,651,559.83	88,943,993.29	35,345,823.83	20,830,968.24	4,409,230,682.52
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	4,139,091,554.02	196,582,984.05	208,368,401.96	81,162,887.89	24,431,956.67	4,649,637,784.59

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр компани нийт 1,988,328,466.72 төгрөгийн өртөгтэй өөрийн эзэмшлийн газар , нэг цэгийн үйлчилгээний барилгыг ХХБ-ны зээлийн барьцаанд барьцаалсан.

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

13 Дансны болон бусад өглөг

13.1 Дансны өглөг

Дансны өглөг дансны хураангуй дараах байдалтай байна.

(Төгрөгөөр)	2023.12.31	2024.12.31
Худалдан авалтын төлбөрийн өглөг	1,284,676.76	1,284,677.05
Дүн	1,284,676.76	1,284,677.05

13.2 Бусад өглөг

Бусад өглөг дансны хураангуй дараах байдалтай байна.

(Төгрөгөөр)	2023.12.31	2024.12.31
Худалдан авалтын өглөг	11,818,182.80	12,717,580.80
Дүн	11,818,182.80	12,717,580.80

14 Урьдчилж орсон орлого

Компани нь бүтээгдэхүүн хүргэлттэй уялдуулан тайлант хугацааны орлогоор хүлээн зөвшөөрдөг. Жил бүр дараагийн тайлант хугацаанд ногдох орлогыг богино хугацаат урьдчилж орсон орлогын дансанд бүртгэн тайлагнасан.

Урьдчилж орсон орлогын мэдээллийг харилцагчийн байдлаар авч үзвэл дараах байдалтай байна.

(Төгрөгөөр)	2023.12.31	2024.12.31
Урьдчилж орсон орлого	3,400,000.00	-
Түрээсийн орлого	-	-
Дүн	3,400,000.00	-

15 Нөөц өр төлбөр

Нөөц өр төлбөр байгуулаагүй, үлдэгдэлгүй байна.

16 Татварын өглөг

Татварын өглөгийн хураангуй дараах байдалтай байна.

(Төгрөгөөр)	2023.12.31	2024.12.31
Аж ахуй нэгжийн орлогын албан татварын өглөг	27,338,767.52	74,173,013.31
Нэмэгдсэн өртгийн албан татварын өглөг	35,895,170.02	23,171,235.53
Хувь хүний орлогын албан татварын өглөг	16,981,776.81	37,123,937.32
Дүн	80,215,714.35	134,468,186.16

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

17 Орлогын татварын зардал

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилд орлогын албан татвар дараах байдалтай байна:

(төгрөгөөр)	2023.12.31	2024.12.31
Татвар төлөхийн өмнөх ашиг	635,141,238.16	763,226,839.17
Тусгай орлого	-	-
Хасагдахгүй зардал	26,704,012.74	107,864,623.40
Байнгын зөрүүгээр зохицуулагдсан	-	-
Татварын түр зөрүү	-	-
Ханшийн бодит бус олз	-	-
Хэрэгжсэн олз	-	-
Түр зөрүүгээр зохицуулагдсан	-	-
Нийтлэг хувь хэмжээгээр суутгуулсан татвар	-	87,583,496.29
Тусгай хувь хэмжээгээр суутгуулсан	-	474,350.03

2020 оноос хэрэгжиж байгаа ААНОАТ-ын шинэ хуулийн дагуу тайлант үеийн Орлогын албан татварыг 10 хувиар ногдуулсан. Монгол Улсын татварын эрх бүхий байгууллага нь өөрийн хуулийн талаарх тайлбар болон байр сууриндаа илүү хатуу хандаж болох бөгөөд өмнө нь татварын аливаа асуудал үүсэж байгаагүй ажил гүйлгээ, үйл ажиллагаанд татварын аливаа асуудал үүсэхийг үгүйсгэхгүй юм. Үүний үр дүнд, нөлөөлөхүйц хэмжээний нэмэлт татвар, торгууль болон хүүг ногдуулж болох юм. Татварын шалгалт хийх хугацааны хувьд шалгалт хийх тайлант жилээс өмнөх 4 жилийн хугацааг хамарч болно. Зарим тухайлсан тохиолдолд түүнээс ч урт хугацааг хамарч болно.

Үнэ шилжилттэй холбоотой Монгол Улсын хуулийн заалтууд нь 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн ба тодорхой онцлог шинж чанарыг агуулсан ч Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагаас боловсруулсан олон улсын үнэ шилжилттэй холбоотой зарчимд ерөнхийдөө суурилсан. Үнэ шилжилттэй холбоотой хуулийн зохицуулалт нь тухайн байгууллагын хяналтад байгаа ажил гүйлгээнүүд (холбоотой талуудын хооронд хийгдсэн ажил гүйлгээ, мөн зарим холбоогүй талуудын хооронд хийгдсэн ажил гүйлгээ) хэрэв сунгасан гарын зарчмаар хэрэгжээгүй бол татварын аливаа эрсдэл үүсэх зохицуулалттай. Удирдлага нь одоогийн үнэ шилжилттэй холбоотой хууль тогтоомжийг дагаж мөрдөх төлөвлөгөө, журмыг хэрэгжүүлж байгаа.

18 Эдийн өмч

Хувьцаат капитал нь тайлант хугацааны эцэст дараах үлдэгдэлтэй байна.

Хувьцаа эзэмшигчдийн нэр:	2023он		2024 он	
	Эзэмшиж буй хувьцааны дүн/төг/	Хувь эзэмшил	Эзэмшиж буй хувьцааны дүн/төг/	Хувь эзэмшил
Э-Транс ложистикс ХК	2,310,000,000	50%	4,524,445,400	97.9%
Би Ди Сек ХК	1,373,977,000	29.74%	-	0.0%
Тагтан инвест ХХК	510,229,800	11.04%	-	0.0%
ZHNR ALEHANDER	169,856,700	3.68%	-	0.0%
Би Ди Пи Эй Эф ХХК	128,445,700	2.78%	-	0.0%
Бусад ААН	6,925,400	0.15%	5,670,500	0.1%
Монгол улсын иргэд	86,618,300	1.87%	58,229,200	1.3%
Гадаад улсын иргэд	33,947,100	0.73%	31,530,600	0.7%
НИЙТ ДҮН	4,620,000,000	100%	4,619,875,700	100.0%
Үүнээс тусгаарлагдсан:				
Монгол улсын иргэд/З/	-	-	124,300	0.003%

Компанийн дүрмийн сан нь тайлант хугацааны эцэст нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 46,200,000 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байна.

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

Компанийн хуримтлагдсан ангийн данс нь дараах байдалтай байна.	
(Төгрөгөөр)	Тайлан жилийн дун
2023.12.31-ний үлдэгдэл	(13,507,934.73)
Хуваарилсан ногдол ашиг	277,200,000.00
Орлогын албан татварын буцаалт	-
Тайлант жилийн цэвэр ашгаар нэмэгдсэн	680,386,843.18
2024.12.31-ний үлдэгдэл	389,678,908.45

19 Орлого

Борлуулалтын орлого дараах байдалтай байна:		
(Төгрөгөөр)	2023.12.31	2024.12.31
Ачилтын орлого	143,006,272.73	368,066,663.64
Хадгалаалтын орлого-гарах хуудасны орлого	1,370,129,999.87	1,489,988,779.72
Баталгаат агуулахын орлого	401,379,338.18	297,902,040.00
Бусад үйлчилгээний орлого	570,070,837.07	228,980,914.20
Чингэлтийн орлого	-	1,304,443,097.85
Түрээсийн орлого	53,046,059.99	82,681,820.29
Дүн	2,537,632,507.84	3,772,063,315.70

20 Үйл ажиллагааны зардал

Үйл ажиллагааны зардал дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)	2023.12.31	2024.12.31
Борлуулалт маркетингийн зардал	1,875,787,256.95	2,847,992,923.08
Дүн	1,875,787,256.95	2,847,992,923.08

20.1 Бусад орлого, зардал

Бусад зардлын дэлгэрэнгүй дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)	2023.12.31	2024.12.31
Тэтгэмжийн зардал	600,000.00	6,311,110.00
Хандив тусламж	-	100,000,000.00
Алданиг торгуулийн зардал	800,000.00	-
Хөрөнгө ажилгүйдэл устгасны зардал	-	-
Бусад зардал	25,304,012.73	1,553,513.40
Дүн	26,704,012.73	107,864,623.40

20.3 Цалингийн зардал

(Төгрөгөөр)	2023.12.31		2024.12.31	
	Ажиллагсдын тоо	Цалингийн зардал	Ажиллагсдын тоо	Цалингийн зардал
Борлуулалт, маркетингийн	33	766,455,831.41	41	1,074,873,859.00
Дүн	33	766,455,831.41	41	1,074,873,859.00

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

21 Бусад ашиг, алдагдал

(Төгрөгөөр)	2023.12.31	2024.12.31
Санхүүгийн орлого	1,013,882.53	4,743,500.30
Санхүүгийн зардал	-	48,235,429.77
Дүн	1,013,882.53	(43,491,929.47)

22 Эрсдэлийн удирдлагын тогтолцоо

Компанийн удирдлага нь Компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгох, түүнийг хянах ерөнхий үүрэг хариуцлагыг хүлээж байдаг. Түүнчлэн Компанийн удирдлага нь эрсдэлийн удирдлагын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих зэрэг үйл ажиллагаа өлөр тутам хийгдэж байгаа эсэхэд үүрэг хариуцлага хүлээдэг. Удирдлага нь хувьцаа эзэмшигчдэд үйл ажиллагааныхаа талаар тайлагнадаг.

Компанийн эрсдэлийн удирдлагын бодлого нь Компанид тулгарч буй эрсдэлүүдийг тодорхойлох, шинжлэх, тохиромжтой эрсдэлийн хязгаар, хяналтыг бий болгох, эрсдэлийг хянах, хязгаарыг мөрдөхөд чиглэгдсэн байдаг. Эрсдэлийн удирдлагын бодлого болон систем нь зах зээлийн нөхцөл байдал болон Компанийн үйл ажиллагаанд гарч байгаа аливаа өөрчлөлтүүдийг тусгахын тулд байнгын хяналт сайжруулалтын дор байдаг. Компани нь өөрийн сургалт, удирдлагын стандарт болон дүрэм журмаараа дамжуулан ажилтнууд өөрсдийн үүрэг хариуцлагыг бүрэн ухамсарласан байх зохион байгуулалт бүхий, бүтээлч хяналт бүхий орчныг бий болгохоор зорин ажлахаар байна.

Э-Транс логистикс ХК нь зээлийн болон бусад эрсдэлийн удирдлагаар хангах үүрэгтэй бөгөөд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зөвшөөрөл шаардлагатай буюу тодорхой түвшнээс дээш хэмжээний томоохон хэлцлүүдийг хянан үзэх байдлаар ажилладаг. Мөн түүнчлэн худалдан авалт болон борлуулалтын урт хугацаатай гэрээ, хэлцэл болон капитал хөрөнгө оруулалт, зээл зэрэг харьцангуй товөгтэй урт хугацааны шинжтэй хэлцлүүдэд хэлэлцээр хийх болон зохион байгуулалтыг Хувьцаа эзэмшигчийн хурлаар хэлэлцэн шийдвэр гаргадаг.

22.1 Төлбөрийн чадварын эрсдэл

Төлбөрийн чадварын эрсдэл нь санхүүгийн өр төлбөртэй хамаарал бүхий үүрэг хариуцлага биелүүлэхэд компанид тулгарч болох аливаа хүндрэлүүд юм. Компанийн төлбөрийн чадвараа удирдах арга хандлага нь өр төлбөрийг хугацаанд нь барагдуулах хангалттай төлбөрийн чадвартай байх, үл хүлээн зөвшөөрөгдөх аливаа алдагдлыг хүлээхгүй байх.

Дараах хүснэгтээрх мэдээлэл нь компанийн санхүүгийн өр төлбөрийг төлөхөд бэлэн байдал, түүнийг төлөх нөөцийн боломжийг харуулна.

(Төгрөгөөр)	2023.12.31	2024.12.31
Санхүүгийн хөрөнгө	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	571,517,003.97	1,688,511,269.25
Дансны авлага болон бусад авлага	21,495,784.15	1,734,727,718.13
Дүн	593,012,788.12	3,423,238,987.38
Санхүүгийн өр төлбөр	-	-
Богино хугацаат өр төлбөр	21,115,288.86	14,002,257.85
Татварын өглөг	80,215,714.35	133,993,836.13
Урт хугацаат өр төлбөр	-	-
Дүн	101,331,003.21	147,996,093.98

22.2 Валютын ханшийн эрсдэл

Компани өөрийн үйл ажиллагааны валют болох төгрөгөөс бусад валютаар илэрхийлэгдсэн борлуулалт, худалдан авалт, зээлд гадаад валютын ханшийн эрсдэлийг хүлээдэг. Эдгээр ажил гүйлгээний илэрхийлэгдсэн үндсэн валют нь Америкийн доллар юм. Компани валютын ханшийн эрсдэлээс зайлсхийхийн тулд гадаад валютын хэлбэлзлийг тогтмол хянаж, ирээдүйн гадаад валютын мөнгөн урсгалаа удирддаг.

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

Тайлант жилийн эцэс дэх Монгол банкны хавтгын ханшийг дор үзүүдэв.

Мөнгөн гэмдэгт	2023.12.31	2024.12.31	Хэлбэлзэл /+/-
	(төгрөг, мөнгөөр)	(төгрөг, мөнгөөр)	
Ам.Доллар	3,410.69	3,420.25	-9.56
Юань	480.01	468.57	11.44

22.3 Хүүгийн түвшний эрсдэл

Хүүгийн түвшний эрсдэл нь голдуу хөвөгч хүүтэй хадгаламж, эзэлд тохиолдож болох хүүгийн түвшний ирээдүйд гарах өөрчлөлтийн хэлбэлзлийн эрсдэл юм. Хүүгийн түвшний эрсдэлийн удирдлагын зорилго нь санхүүгийн зардлыг хамгийн бага байлгах болон хүүгийн түвшний өөрчлөлттэй холбоотой тодорхой бус байдлыг бууруулахад чиглэдэг.

Хүүгийн түвшний өөрчлөлттэй холбоотойгоор хүлээх зах зээлийн эрсдэл нь голдуу Компанийн зээлтэй хамааралтай байдаг.

22.4 Үйл ажиллагааны эрсдэл

Компанийн санхүүгийн удирдлагын бодлого болон зарчим нь компанийн эзэлжх дээд хязгаар, капиталын бүтэц, эргэлтийн хөрөнгийн удирдлага, хөрвөх чадварууд дээр санхүүгийн харьцаануудын зохистой түвшнийг тогтоох замаар санхүүгийн болон үйл ажиллагааны шилдэг арга туршлагыг нэвтрүүлэхийг зорилго болгодог байна. Мөн түүнчлэн зорилгот ашигт ажиллагаа, өөрийн хөрөнгийн өгөөжийн түвшнийг тогтоохдоо зах зээлийн нөхцөл байдал болон зорилот салбарын онцлогийг харгалзан үздэг.

Санхүүгийн тогтвортой байдлыг хангахын тулд Компанийн хөрөнгө оруулалт болон тогтоосон санхүүгийн харьцаануудыг тодорхой түвшинд хангаж байх хэмжээнд өөрсдийн бизнесийн төлөвлөгөө болон үйл ажиллагааны төсвийг боловсруулж, хэлэлцэн хэрэгжүүлдэг. Түүнчлэн, санхүүгийн харьцаануудын гүйцэтгэлийн биелэлт нь жилийн гүйцэтгэлийн үнэлгээний системд багтсан ба гүйцэтгэх удирдлагын багийн гүйцэтгэлийн үнэлгээ болон тэдний цалингийн хувьсах бүрэлдэхүүн хэсэгт (урамшуулал цалин) чухал ач холбогдолтой. Компанийн санхүүгийн удирдлагад ашиглагдаж хамгийн түгээмэл санхүүгийн харьцаанууд нь:

- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа = Эргэлтийн хөрөнгө/Богино хугацаат өр төлбөр;
- Зээл/Хүү, татвар, элэгдэл, хорогдлын өмнөх ашиг (ХТЭХОА);
- Эргэцийн харьцаа, хоног (авлага, бараа материал болон өглөг);
- Зээлийн үйлчилгээ хийх чадварын харьцаа = Чөлөөт мөнгөн урсгал/Зээлийн үйлчилгээний дүн;
- Өгөөжийн дотоод норм;
- Ашигт ажиллагааны зорилгот түвшин: ХТЭХОА маржин, татварын дараах ашгийн маржин.

Э-Транс ложистикс ХК нь зорилгот хөрөнгө оруулалтын өгөөжийг бий болгохын зэрэгцээ, компанийн хэмжээнд эрсдэлийг хамгийн бага хэмжээнд байлгахын тулд эрсдэлийн иж бүрэн цогц удирдлагын системийг бий болгохоор зорин ажиллаж байна.

23 Капиталын удирдлага

Компанийн капиталд хөрөнгө удирдлагын зорилгоор, хөрвөх нөхцөлтэй хувьцаа, хувьцааны урамшуулал болон эздийн өмчид хуваарилагдах бусад бүх капиталын нөөцийг оруулна. Компанийн хөрөнгийн удирдлагын үндсэн зорилго нь өөрийн бизнесийг дэмжих ба хувь нийлүүлэгчдийн хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршино.

Компанийн өрийг өмчид харьцуулсан харьцааг тайлант хугацааны эгсэгт илэрхийлбэл:

(Төгрөгөөр, өрийн харьцаанаас бусдаар)	2023.12.31	2024.12.31
Нийт өр*	101,331,003.22	3,287,337,665.64
Нийт эздийн өмч	5,535,350,145.40	5,939,153,258.48
Өрийн харьцаа	1.83%	55.35%

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

24 Холбоотой талууд

24.1 Хувьцаа эзэмшигчид болон компанийн удирдлага

Компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилд холбоотой талуудын хамаарал болон хийгдсэн ажил гүйлгээ дараах байдалтай байна.

24.2 Холбоотой талуудтай хийгдсэн ажил гүйлгээ:

Ногдол ашигтай холбоотой ажил гүйлгээ.

Хувьцаа эзэмшигчид	Харьяалал	Харилцан хамаарал	Холбоотой гүйлгээ
Э-Транс ХХК	Монгол улс, ААН	Хувьцаа эзэмшигч	Ногдол ашиг
Би Ди Сек ХХК	Монгол улс, ААН	Хувьцаа эзэмшигч	Ногдол ашиг
Тасган инвест ХХК	Монгол улс, ААН	Хувьцаа эзэмшигч	Ногдол ашиг
Би Ди Пи Эй Эф ХХК	Монгол улс, ААН	Хувьцаа эзэмшигч	Ногдол ашиг
Бусад	Иргэд, аж ахуйн нэгж	Хувьцаа эзэмшигч	Ногдол ашиг

24.3 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ:

Ногдол ашигтай холбоотой ажил гүйлгээ:

Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	Нэгж хувьцаанд ногдох ашиг	Зарласан ногдол ашиг	Суутгуулсан ХХОАТ 5%	Хүлээн авсан ногдол ашиг
Э-Транс ХХК	23,100,000	6	138,600,000.00	13,860,000.00	124,740,000.00
Би Ди Сек ХХК	13,739,770	6	82,438,620.00	4,121,931.00	78,316,689.00
Тасган инвест ХХК	5,102,298	6	30,613,788.00	1,530,689.40	29,083,098.60
Би Ди Пи Эй Эф ХХК	1,284,457	6	7,706,742.00	385,337.10	7,321,404.90
Бусад	3,008,639	6	18,051,834.00	2,949,063.20	15,102,770.80
ДҮН	46,200,000		277,410,984.00	22,847,020.70	254,563,963.30

24.4 Бусад холбоотой талууд

Бусад холбоотой талуудад хувьцаа эзэмшигчид болон тэдний гэр бүлийн гишүүд болон гишүүдтэй холбоотой байгууллагууд, компанитай адил нэг захирал эсвэл гол удирдлагатай байгууллагууд, захирал болон гол удирдлага мөн тэдгээрийн гэр бүлийнхэнтэй холбоотой байгууллагууд хамаарна.

25 Үүрэг хариуцлага ба болзошгүй зүйлс

25.1 Хууль, эрх зүй

Компани нь бизнесийн ердийн үйл ажиллагааны явцад ч хуулийн аливаа зарга маргаан болон гомдолтой холбогдож болно. Хэрэв аливаа зарга маргаан, гомдол гарснаас ямар нэгэн үүрэг хариуцлага үүсвэл энэ нь Компанийн ирээдүйн үйл ажиллагааны үр дүн болон санхүүгийн байдалд материаллаг сөрөг нөлөө үзүүлэхгүй гэдэгт удирдлага итгэлтэй байна.

25.2 Байгууллагын үйл ажиллагаа, эдийн засгийн нөлөө

Хилийн боомтын өргөтгөлийн ажил дуусаж, ижил төрлийн үйл ажиллагаа эрхлэх компанийн тоо нэмэгдэж орлого хүрсэн төвшингээ буурахаар байсан ч импорттоор оруулж байгаа тээврийн хэрэгслийг УБ хот руу вагоноор тээвэрлэж байсан нь ихээхэн хүндрэл учруулж байсныг, автомашинаар оруулах болсонтой холбоотойгоор, чингэлгийг өндөрлөсөн талбайд буулган задалж, бүрдүүлэлт хийсний дараа олгох үйл ажиллагааг эрхлэх болсноор нийт борлуулалтын орлого өмнөх оноос 48.3 хувиар өссөн.

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

26 Тайлангийн дараах үйл явдал

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 1 дүгээр тогтоолоор Э-Транс Ложистикс ХК-ийн үйл ажиллагааг сайжруулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник тэнэг төхөөрөмжийн шинэчлэх ажлыг 2025 хийхээр төлөвлөсөн тул 2024 оны үйл ажиллагааны орлогоос ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн байна.

Удирдлага нь санхүүгийн тайланд нөлөөлөхүйц тайлант хугацааны дараа гарсан бусад үйл явдал байхгүй гэж үзэж байна.

ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК

Мэргэшсэн няглан бодогчид

Улаанбаатар хот, Монгол Улс

Огноо: 2025 оны 03 дүгээр сарын 21



1.2.

**Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг
энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/**



"ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ" ХХК
 НИЯТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТ БИЗНЭС ЗӨВЛӨГӨӨ

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2 дугаар хороо,
 Төмөрний гудамж, 8 дугаар байр, 1003 тоот
 Утас: (+976) 7000 – 1778, Утас: (+976) 7000 – 1778,
 И-мэйл: info@imkaudit.mn, Вeб хуудас: www.imkaudit.mn

2025.03.21 № 0/2025/05

Танай _____ -ны № _____ -т

**ХАРААТ БУС АУДИТОРЫН
 ДҮГНЭЛТ**

Зөрчилгүй дүгнэлт

Бид "Э-Транс ложистикс" ХК (шашид "Компани"гэх)-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд, Компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн, шударгаар толилуулсан байна гэж дүгнэж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт ("АОУС")-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлага энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт тайлбарласан. Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЕЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад танигддаг ёс зүйн шаардлагын дагуу Бид компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЕЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу танигддаг ёс зүйн үүрэг хариуцлага бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, толилуулах нь компанийн удирдлагын үүрэг болно. Энэхүү үүрэг хариуцлагад санхүүгийн тайлангуудыг залилан юм уу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу нэрхийлэлгүйгээр бэлтгэж, шударгаар толилуулахтай холбоотой дотоод хяналтын системийг зохиож, хэрэгжүүлэн, түүнийгээ тууштай ажиллуулах, нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож, хэрэглэх, нөхцөл байдалд тохируулан нягтлан бодох бүртгэлийн тооцоолуудыг хийх зэрэг зүйлс багтана.

Аудиторын үүрэг хариуцлага

Бидний үнэмэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитаа төлгөвчлэн эдгээо санхүүгийн тайлангчдад

**Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК-
 ИЙН ХУВЬЦЛАА
 ЭЗЭМШИГЧДЭД**

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудыг баримталж, санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлөгдсөн эсэх талаар ул үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилан сонгодог бөгөөд үүнд, залилан юм уу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу нэрхийллийн эрдэлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрдэлийн тооцооллыг хийхтэй холбоотойгоор, аудитор компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг сонгож хэрэглэх зорилгоор компанийн санхүүгийн тайланг бэлтгэж, шударгаар толилуулахад зориулан хэрэглэж байгаа дотоод хяналтыг авч үздэг. Мөн санхүүгийн тайлагналыг бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцоолуудын үндэслэлтэй байдал, хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан. Бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж бид итгэж байна.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайлан нь Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан ба аливаа нэгэн өөр зорилго агуулаагүй болно.

Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө үүрэг хариуцлага хүлээхгүй болно.

Бусад хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаарх тайлан

Түүнчлэн, санхүүгийн тайланг бэлтгэхдээ Монгол улсад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчмууд болон Сангийн Сайдын тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн заавартай нийцж байна.

ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК


Мэргэшсэн нягтлан бодогчид
 Улаанбаатар хот, Монгол Улс
 Огноо: 2025 оны 03 дүгээр сарын 21




(Signature)
 С.ТУНГАЛАГ
 Захирал

2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл																														
2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/																														
	<p>2024 онд тус компанийн үйл ажиллагаа улс орны эдийн засгийн нөхцөл байдал сайжирч байгааг даган өмнөх жилүүдийн байдлаас сайжирч нэлээдгүй ажил үйлчилгээтэй, ашиг орлого нэмэгдсэн. Үндсэн үйл ажиллагаа болох төмөр замаар шилжүүлэн ачих үйл ажиллагаа зорилтот түвшинд хүрээгүй боловч шилжүүлэн ачилтын орлого өмнөх жилийн мөн үеийнхээс өссөн байна. Гаалийн хяналтын бүсэд нэвтэрч гаалийн бүрдүүлэлт хийсэн тээврийн хэрэгсэл өмнөх жилүүдийнхээс нэлээдгүй тоогоор ихссэн бөгөөд энэ нь тус гаалийн хяналтын бүс дэх өндөрлөсөн тавцанг ашиглан чингэлгээр орж ирсэн автомашиныг буулгах ажлыг гаалийн байгууллагатай хамтран зохион байгуулсны үр дүн юм. Энэхүү ажлын хүрээнд 3823 тээврийн хэрэгслээр оруулж ирсэн чингэлгийг задалж ойролцоогоор 15,200 автомашиныг буулгах ажлыг хийж гүйцэтгэжээ. Гаалийн хяналтын бүсэд өмнөх жилд 27039 тээврийн хэрэгсэл нэвтэрч байсан бол 2024 онд 38526 тээврийн хэрэгсэл нэвтэрч гаалийн хяналт шалгалтад хамрагдсан нь өмнөх жилүүдэд тус гаалийн хяналтын бүсэд орж ирж байгаагүй тоо хэмжээ юм.</p> <table border="1" data-bbox="338 760 1841 1112"> <thead> <tr> <th>д/д</th> <th>Орлогын нэр</th> <th>2023 он</th> <th>2024 он</th> <th>Зөрүү</th> <th>Өсөлт бууралт</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Ачилтын орлого</td> <td>143,006.3</td> <td>368,066.6</td> <td>225,060.3</td> <td>1,5 дахин өссөн</td> </tr> <tr> <td>2</td> <td>Хадгалалт болон гарах хуудас</td> <td>1,771,509.3</td> <td>1,787,745.0</td> <td>16,235.7</td> <td>0,9% өссөн</td> </tr> <tr> <td>3</td> <td>Түрээсийн орлого</td> <td>53,046.1</td> <td>82,682.0</td> <td>29,635.9</td> <td>55,8% өссөн</td> </tr> <tr> <td>4</td> <td>Бусад орлого</td> <td>570,070.8</td> <td>1,533,569.4</td> <td>963,498.6</td> <td>1,6 дахин өссөн</td> </tr> </tbody> </table> <p>Компанийн үйл ажиллагааны хүрээнд өмнөх жилүүдтэй харьцуулсан зарим голлох үзүүлэлтүүдийг графикаар гаргаж үзүүлбэл:</p>	д/д	Орлогын нэр	2023 он	2024 он	Зөрүү	Өсөлт бууралт	1	Ачилтын орлого	143,006.3	368,066.6	225,060.3	1,5 дахин өссөн	2	Хадгалалт болон гарах хуудас	1,771,509.3	1,787,745.0	16,235.7	0,9% өссөн	3	Түрээсийн орлого	53,046.1	82,682.0	29,635.9	55,8% өссөн	4	Бусад орлого	570,070.8	1,533,569.4	963,498.6	1,6 дахин өссөн
д/д	Орлогын нэр	2023 он	2024 он	Зөрүү	Өсөлт бууралт																										
1	Ачилтын орлого	143,006.3	368,066.6	225,060.3	1,5 дахин өссөн																										
2	Хадгалалт болон гарах хуудас	1,771,509.3	1,787,745.0	16,235.7	0,9% өссөн																										
3	Түрээсийн орлого	53,046.1	82,682.0	29,635.9	55,8% өссөн																										
4	Бусад орлого	570,070.8	1,533,569.4	963,498.6	1,6 дахин өссөн																										

Гаалийн хяналтын бүсэд нэвтэрсэн тээврийн хэрэгсэл



2012-2024 ОНЫ ШИЛЖҮҮЛЭН АЧИЛТЫН ТОО



2.2.

**Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц,
боломжийн үзүүлэлт**

Хөрөнгийн байдлын үнэлгээ		
Төрөл	Үзүүлэлт	Дүгнэлт
	2024	
Хөрөнгийн өсөлтийн хурд	0.1	Үндсэн хөрөнгийн өсөлтийн хурд нь 0.1 хувь байна.
Эргэлтийн хөрөнгийн хувийн жин	47.14	Эргэлтийн хөрөнгийн эзлэх хувийн жин өмнөх оныхоос 2,8 дахин өссөн байна. Хөрөнгийн хөрвөх чадвар сайн Нийт хөрөнгийн 47.14 хувийг эзэлж байна
Санхүүгийн байдлын үнэлгээ		
Төрөл	Үзүүлэлт	Дүгнэлт
	2024	
Ажлын капитал	4,158,446,250.63	Ажлын капитал сайн ба ямар нэгэн өр төлбөрийн дарамтын эрдсэл бага байна. Ажлын цэвэр капитал нь компанийн хөрвөх чадварын чухал үзүүлэлт ба мөнгөн дүнгээр илэрхийлэгдэнэ. Өмнөх оныхоос 3,313,026,076.71 төгрөгөөр өссөн байна.
Ажлын капиталын оролцоо	0.95	Өр төлбөрийн дарамтанд орох эрсдэл бага.Компанийн хөрвөх чадвар сайн байна.
Эргэлтийн харьцаа	23.4	Эргэлтийн хөрөнгөөр богино хугацаат өр төлбөрийг барагдуулах чадвар сайн. Эргэлтийн харьцаа сайн.
Өрийн харьцаа	2.77	Компанийн өр зээл бол ашиг нэмэгдүүлэх, ашиг олох зорилгоор ашиглаж байгаа хүмүүсийн мөнгө. Тиймээс зээл санхүүжилт авч үйл ажиллагааг өргөтгөх шаардлагатай. Нийт эх үүсвэрт зээлийн эх үүсвэрийн эзлэх хувийн жин юм.

2.3.	<p>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</p>	
	<p>2024 оны 10 сарын 16-ны өдөр тус компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч Э-Транс ХХК-ийн хувьцаа эзэмшил 75 хувийг давсан тул 2024 оны 11 сарын 13-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурлаар Компанийн тухай хуулийн 54.4 дэх заалтийг үндэслэн бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Уг хурлаар Э-Транс ХХК-нд хувьцаагаа худалдан авах зөвшөөрлийг олгож, хувьцаагаа эргүүлэн худалдаж авах хувьцааны үнийг 118.08 төгрөгөөр, хувьцаагаа худалдан авах саналын эхлэх өдрийг 2024 оны 11 сарын 18-ны өдрөөр, санал дуусах хугацааг 2024 оны 12 сарын 19-ний өдрийг дуустал байхаар тогтоосон. Энэхүү шийдвэрийн дагуу Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв болон Э-Транс ХХК-тай гурвалсан гэрээ байгуулан хувьцаагаа худалдах хүсэлт ирүүлсэн 3 хувьцаа эзэмшигчийн 66,414 ширхэг хувьцааг худалдан авч хувьцааны төлбөрийг шилжүүлүүлсэн байна.</p>	
2.4.	<p>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/</p>	<p>Байхгүй</p>
2.5.	<p>Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;</p>	<p>2024 оны 08 сарын 12-нд компанийн үйл ажиллагааг өргөтгөж ашиг орлогыг нэмэгдүүлэх зорилгоор “Э-транс ложистикс” ХК-ийн барилгын ойролцоох нийтийн эзэмшлийн газрыг худалдан авах, засварлахад шаардлагатай ажлуудыг хийж гүйцэтгэх зорилгоор Худалдаа, хөгжлийн банкаас хөрөнгө оруулалтын зээл судлуулан 3 тэрбум төгрөгийн зээлийг авсан. Зээлийн барьцаанд компанийн үл хөдлөх эд хөрөнгө болох офиссын байр, уурын зуух, агуулахуудыг, газар эзэмших эрх зэргийг барьцаалсан байна. Зээлийн эргэн төлөлт хэвийн.</p>
3.	<p>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</p>	
	<p>Сонирхолын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй.</p>	
4.	<p>Цалин урамшууллын мэдээлэл</p>	

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь компаниас цалин урамшуулал авдаггүй болно. Тус компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс тухайн компанийн хувьцааг эзэмшдэг гишүүн байхгүй, санхүүгийн жилийн хугацаанд гүйцэтгэх захирал 38,456,000 төгрөгийн цалин урамшуулал авсан байна.

5. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр цахимаар зохион байгуулагдсан компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгосон.

д/д	Овог нэр	Албан тушаал	Хувьцаа эзэмшилт	Боловсрол	ТУЗ-ын хуралд оролцсон байдал	Ажлын туршлага
1.	Энхболдын Батболд	ТУЗ-ын дарга, хараат гишүүн	Эзэмшдэггүй	Дээд	100%	Баянцемент ХХК, Ерөнхий захирал
2.	Чулууны Энхболд	ТУЗ-ын хараат гишүүн	Эзэмшдэггүй	Дээд	100%	Э-Транс ХХК, Ерөнхий захирал
3.	Амарсанаагийн Бат-Орших	ТУЗ-ын хараат гишүүн	28,260ш 0,06%	Дээд	100%	Баянцемент ХХК, Үйл ажиллагаа хариуцсан дарга
4.	Бүрэнмэндийн Лхагвадорж	ТУЗ-ын хараат гишүүн	Эзэмшдэггүй	Дээд	75%	Би Ди Сек ХК, Гүйцэтгэх захирал
5.	Данзангийн Даянбилгүүн	ТУЗ-ын хараат гишүүн	Эзэмшдэггүй	Дээд	75%	Би Ди Сек ХК, Ерөнхийлөгч
6.	Одгийв Уранбайгаль	ТУЗ-ын хараат гишүүн	Эзэмшдэггүй	Дээд	75%	Би Ди Сек ХК, басoffice албаны менежер
7.	Халтарын Батхишиг	ТУЗ-ын хараат бус гишүүн	Эзэмшдэггүй	Дээд	60%	Нефть ойл ХХК, Захирал

8.	Жаргалсайханы Энхтулга	ТУЗ-ын хараат бус гишүүн	Эзэмшдэггүй	Дээд	100%	Лайф ис Гүүд Монголиа ХХК, нягтлан бодогч
9.	Чулуунбаатарын Оргил	ТУЗ-ын хараат бус гишүүн	Эзэмшдэггүй	Дээд	100%	МГТБҮ ТӨХХК, гэрээний ахлах






ТУЗ-ын даргаар Э.Батболд, аудитын хороонд Ж.Энхтулга / дарга /, гишүүд Х.Батхишиг, Б.Лхагвадорж, нэр дэвшүүлэх хороонд Ч.Оргил / дарга /, гишүүд Ж.Энхтулга, А.Бат-Орших, цалин урамшууллын хороонд Х.Батхишиг / дарга /, гишүүдэд Ч.Оргил, Д.Даянбилгүүн нар сонгогдон ажиллаж байна.

Компанийн засаглалийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан мэдээг гаргаж Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржийн холбогдох хэлтэст хүргүүлж үнэлүүлсэн. Цаашид компанийн засаглалыг бэхжүүлэх кодексийн хэрэгжүүлэлтийг сайжруулах, шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

2024 оны 02 сард гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа нь хүнд өвчний улмаас нас барсан тул гүйцэтгэх захирлын үүргийг Ерөнхий нягтлан бодогч Э.Ариунтуяа түр орлон гүйцэтгэж байгаад 2024 оны 05 сарын 25-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн хурлаар Чулууны Энхболдыг гүйцэтгэх захирлаар томилж хөдөлмөрийн гэрээ байгуулсан.

д/д	Овог нэр	Албан тушаал	Боловсрол, мэргэжил	Ажлын туршлага
1.	Чулууны Энхболд	Гүйцэтгэх захирал	Дээд, инженер	Тус компанийг үүсгэн байгуулсан.
2.	Эрдэнэбаатар Ариунтуяа	Ерөнхий нягтлан бодогч	Дээд, математикч, нягтлан бодогч	2011 оноос хойш ажиллаж байна.
3.	Гомбо Оюунгэрэл	Гаалийн хяналтын талбайн эрхлэгч	Дээд, багш	2011 оноос хойш ажиллаж байна.
4.	Ванданлхүндэв Баасансүрэн	Ачаа тээврийн ахлах мэргэжилтэн	Дээд, Эрүүл ахуйч	2011 оноос хойш ажиллаж байна.
5.	Содномцэрэн Ганбат	Дотоод ажил хариуцсан ажилтан, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	Дээд, хуульч цагдаагийн байгууллагын ажилтан	2014 оноос хойш ажиллаж байна.

6.	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл
	<p>Тайлангийн хугацаанд ачаа барааг төмөр замаар шилжүүлэн ачих үйл ажиллагаа үндсэндээ зогссон. Цөөн тохиолдолд зарим төрлийн төмөр хийц төмөр замаар ачигдахаас бусад төрлийн ачаа ачигдахгүй болсон байна. Энэ нь автозамаар тээвэрлэлт хийгдэж байгаагаас шалтгаалахаас гадна УБТЗ-аас салбар замд вагон хуваарилахгүй монопол эрх эдэлж байгаагаас шалтгаалж манай компаниар вагон захиалуулан шилжүүлэн ачилт хийлгэх үйлчлүүлэгч ховордсон болно. Гаалийн хяналтын бүсийн хувьд Гаалийн байгууллагаас ачаа барааг ялгавартай хуваарилаж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар хангалттай хэмжээнд ажиллаж байгаа болно.</p>
7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/
	<p>Э-Транс ХХК / нийт хувьцааны 98,07% / нь 5%-иас дээш хувьцааг дангаараа эзэмшиж байгаа ба бусад жижиг хувьцаа эзэмшигчид 1,92% буюу 889,132 ширхэг хувьцааг эзэмшиж байна.</p>
8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл
	Төсөл хэрэгжүүлэхээр хувьцаа гаргаагүй болно.
9.	Ногдол ашгийн мэдээлэл
	<p>. 2023 оны 02 сарын 17-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн эчнээ хурлын шийдвэрээр компанийн 2022 оны мөнгөн хөрөнгийн үлдэгдэлийн 46 хувь буюу нэгж хувьцаанд 3 төгрөг байхаар тооцон 46,200,000 хувьцаанд нийт 138,600,000 төгрөгийн ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд тарааж 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдөр дансанд нь байршуулсан. 2024 оны 02 сарын 19-ний эчнээ хурлаас 2023 оны санхүүгийн үйл ажиллагааны татварын дараах цэвэр ашгаас нэгж хувьцаанд 6 төгрөг байхаар 277,200,000 төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилахаар 01 тоот шийдвэр гарсанг Хөрөнгийн бирж болон цахим хуудсаар дамжуулан нийтэд хүргэж 2024 оны 11-р сард Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг тарааж дууссан байна. 2025 онд үйл ажиллагааг сайжруулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник тоног төхөөрөмж шинэчлэх, сайжруулах ажлыг хийж гүйцэтгэхээр</p>

	<p>төлөвлөсөн тул 2025 оны 02 сарын 11-ний өдрийн 01 тоот Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор хувьцаа эзэмшигч нарт ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.</p>	
10.	<p align="center">Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл</p>	
	<p>Тус компани нийгмийн хариуцлагын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд: Компаниас тэтгэвэртээ гарсан ахмадын бүртгэлд байдаг 6 ажилтанд сар шинийн баяраар гарын бэлэг хүргүүлсэн. Дотоод журамд заагдсаны дагуу 4 ажилтны ар гэрт гачигдал гарсан учир зохих тусламж тэтгэмжийг олгосон. Мөн 2 ажилтны гэр бүлд бүл нэмсэн, 1 ажилтны хүүхдийн даахь үргээх арга хэмжээ зохион байгуулагдсан тул дотоод журмын дагуу тэтгэмжийг олгосон байна. 2024 онд нийт ажилчид ажлын өндөр амжилт гаргасан тул удирдлагын зүгээс БНХАУ-ын Хайнань мужийн Хайкоу, Саня хот, Өвөрмонголын өөртөө засах орны төв Хөх хотуудад 8 хоногийн аялалд явуулж амраасан.</p>	
	<p align="center">Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:</p>	
	<p>Овог, нэр: Чулуун овогтой Энхболд</p> <p>Албан тушаал: “Э-Транс ложистикс” ХК-ийн гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг: </p> <p>(Тамга/тэмдэг) </p>	<p>Овог, нэр: Содном овогтой Тунгалаг</p> <p>Албан тушаал: “Их Монгол хөлөг аудит” ХХК аудитын компанийн захирал</p> <p>Гарын үсэг: </p> <p>(Тамга/тэмдэг) </p>
	<p align="center">Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:</p>	
	<p>Овог, нэр: Содномцэрэн овогтой Ганбат</p> <p>Албан тушаал: Дотоод ажил, хяналт хариуцсан ажилтан</p> <p>Гарын үсэг: </p>	